

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: БУА-2020/158/СТА-ТШЗ

БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
3-р СУРГУУЛИЙН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

Булган сум 2020 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342729 Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Б.Энхтөр

Утас: 70342729 Цахим хаяг: [Enkhturb@audit.gov.mn](mailto:Enkhturb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14

## 1 Аудитын гэрчилгээ

 <b>БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг, Утас: 7034-2580, Факс: 7034-2580	<b>БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ГУРАВ ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Л.ГЭРЭЛТУЯА ТАНАА</b>
Бодо. Ор. 27 № 96	
Танай _____-ны № _____ Т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>	
<p>2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	
<b>Үүрэг, хариуцлага</b>	
<b>006020195</b>	

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.АНХБАЯР

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сургуулийн захирал Л.Гэрэлтуяад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-аас 2020 оны 02 дугаар сарын 18-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймгийн аудитын газрын аудитор Б.Энхтөр хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын Ерөнхий боловсролын 3-р бүрэн дунд сургууль 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн аудитын газар-т 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Булган сумын Ерөнхий боловсролын 3-р бүрэн дунд сургууль нь Бүтээлч сэтгэлгээтэй, өрсөлдөх чадвартай, өв уламжлалаа дээдэлдэг, эх орон, унаган нутгаа хайрлан бахархдаг, элгэмсэг зөв Монгол иргэнийг төлөвшүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага
- Дунд
- Бүрэн дунд

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого,

журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Засгийн газрын тогтоол, журам

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Журам батлах тухай”
- Засгийн газрын оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын оны 24, 25 дугаар тогтоолууд
- Засгийн газрын оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Засгийн газрын оны 275 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай”
- Засгийн газрын оны 276 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай”

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Булган сумын Ерөнхий боловсролын 3-р бүрэн дунд сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Си Ти Эс” программ хангамж ашигладаг байна.

дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 2 хувиар сонгов.

*Нийт зардал*-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төсвийн хүрээнд зардлын ангиллаар зарцуулалт хийх, сургуулийн хувьд суурь үзүүлэлтийг сонгож ажиллах нь зүйтэй. -холбоотой юм.

2019 оны *Нийт зардал* 17,880.42 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 17,880.42 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь 2 холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй

асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	3,316,139.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	729,459.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	4,045,598.00	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Сахилгын шийтгэл оногдуулсан ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон байна. У.Пүрэвээ 15 хувь-66.5, Г.Жадамба 35 хувь-242.9 мянган төгрөгийн урамшуулал авсан.

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам. тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

2.8.1.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хууль тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Сахилгын шийтгэл оногдуулсан ажилтан албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгохгүй байх,

Анхан шатны баримтгүй гүйлгээ хийхгүй байх, дотуур байрны хүүхдийн хоолны нормативыг барьж ажиллах

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд төсөв батлаагүй. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 894020.8 мянган төгрөг буюу 0 хувьтай байгаа нь 11.26 төгрөг шалтгаалжээ.

Төсвийг хураарийн дагуу зарцуулсан.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Булган сумын Ерөнхий боловсролын 3-р бүрэн дунд сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан

заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

##### **3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

###### **3.1.1 Илрүүлэлт:**

Тээвэр шатахууны анхан шатны баримтыг нярвын тайлангаас хөөн шалгахад төлбөрийн баримт, дуудах хуудас болон илтгэх хуудасгүй байна.

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хууль тус тус зөрчсөн байна.

###### **3.1.2 Эрсдэл:**

Анхан шатны баримтгүй

###### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Анхан шатны баримт дутуу шатахуунд зөвлөмж өгөх саналтай байна. НББ тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалтыг хэрэгжүүлэх.

###### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Хүлээн зөвшөөрсөн

##### **3.2 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

###### **3.2.1 Илрүүлэлт:**

Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогоолог хэрэгжүүлж ажиллаагүй.

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын тогтоол тус тус зөрчсөн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Үдийн цай, дотуур байрны хүүхдийн төсвийг хэтрүүлсэн байх

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

### ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

### БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ЭНХТӨР

2020.02.27

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>29,287,016.00</u></b>	<b><u>42,353,172.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	300,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	300,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	300,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	29,287,016.00	42,053,172.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	2,238,900.00	506,260.00
35110	Тусгай зориулалттай материал	2,238,900.00	491,260.00
35130	Эм боох материал	-	15,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	27,048,116.00	41,546,912.00
35410	Бичиг хэргийн материал	319,500.00	940,400.00
35420	Аж ахуйн материал	20,219,660.00	30,781,170.00
35440	Түлш, шатах тослох материал	-	900,000.00
35460	Хүнсний материал	1,819,956.00	3,235,242.00
35470	Бусад хангамжийн материал	4,689,000.00	5,690,100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,366,571,974.11</u></b>	<b><u>4,332,484,468.79</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,366,571,974.11	4,332,484,468.79

«Audit\_name» «Audit\_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,243,350,640.73	4,209,399,135.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,186,400,000.00	4,186,400,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(75,587,777.72)	(145,361,111.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	61,919,487.00	96,429,148.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,662,137.60)	(21,370,584.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,488,580.00	100,860,580.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,678,426.95)	(18,623,785.39)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	10,565,760.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(528,288.00)
39217	Ном	470,916.00	1,027,416.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	123,221,333.38	123,085,333.42
39301	Програм хангамж	680,000.00	680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(158,666.62)	(294,666.58)
39303	Бусад биет бус хөрөнгө	122,700,000.00	122,700,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,395,858,990.11</u></b>	<b><u>4,374,837,640.79</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>203,377.60</u></b>	<b><u>3,923,350.60</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	203,377.60	3,923,350.60
<b>413</b>	<b>Өглөг</b>	203,377.60	3,923,350.60
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,214,658.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	203,377.60	2,708,692.60
41361	Байгууллагад төлөх өглөг	105,805.60	2,216,817.60
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	97,572.00	491,875.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,395,655,612.51</u></b>	<b><u>4,370,914,290.19</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,395,655,612.51	4,370,914,290.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	122,700,000.00	122,700,000.00
51101	Өмч: - төрийн	122,700,000.00	122,700,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	4,272,955,612.51	4,248,214,290.19
51210	Өмнөх үеийн үр дүн	4,272,955,612.51	4,272,955,612.51

«Audit\_name» «Audit\_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51220	Тайлант үеийн үр дүн	-	(24,741,322.32)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,395,858,990.11</u></b>	<b><u>4,374,837,640.79</u></b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>714,083,794.00</b>	<b>869,279,460.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15,087,794.00</b>	<b>11,698,960.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	14,212,794.00	10,565,760.00
120001	Хувьцааны ногдол ашиг	310,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,902,794.00	10,565,760.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,902,794.00	10,565,760.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	875,000.00	1,133,200.00
122001	Хандив тусламж /дотоод/	875,000.00	1,133,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>698,996,000.00</b>	<b>857,580,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	683,996,000.00	643,164,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	683,996,000.00	643,164,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	14,116,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	14,116,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	200,299,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	200,299,800.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	15,000,000.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	15,000,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>733,516,558.38</b>	<b>894,020,782.32</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>733,516,558.38</b>	<b>894,020,782.32</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	723,900,386.38	881,835,021.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	347,073,012.00	485,465,391.00
210101	Үндсэн цалин	272,073,012.00	338,071,471.00
210102	Нэмэгдэл	45,000,000.00	81,745,630.00
210104	Урамшуулал	30,000,000.00	65,648,290.00

«Audit\_name» «Audit\_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,307,904.00	60,672,157.74
210201	Тэтгэврийн даатгал	27,538,604.00	41,257,067.74
210202	Тэтгэмжийн даатгал	3,442,325.00	4,853,772.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,753,860.00	3,883,018.00
210204	Ажилгүйдлийн даатгал	688,465.00	970,755.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,884,650.00	9,707,545.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	187,500,392.00	198,771,800.00
210301	Гэрэл, цахилгаан	13,253,192.00	15,680,000.00
210302	Түлш, халаалт	164,247,200.00	166,913,300.00
210303	Цэвэр, бохир ус	10,000,000.00	16,178,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,208,714.00	10,397,792.00
210401	Бичиг хэрэг	2,722,400.00	1,287,200.00
210402	Тээвэр, шатахуун	945,000.00	1,485,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,754,274.00	1,696,582.00
210404	Ном, хэвлэл	-	60,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	206,000.00	430,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,581,040.00	4,366,410.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,071,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,133,012.60	22,542,244.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	111,000.00	54,000.00
210502	Хоол, хүнс	2,929,764.60	22,488,244.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	92,248.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,013,150.00	3,783,080.00
210604	Урсгал засвар	34,013,150.00	3,783,080.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	330,000.00	330,000.00
210702	Дотоод албан томилолт	330,000.00	330,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	523,000.00	469,730.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	523,000.00	391,230.00

«Audit\_name» «Audit\_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	78,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	93,811,201.78	99,402,826.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,086,350.00	1,620,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,880,500.00	5,690,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	86,844,351.78	92,091,426.32
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,616,172.00	12,185,761.26
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,924,573.00	12,185,750.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	17,024.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,534,049.00	10,925,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	373,500.00	1,260,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,691,599.00	11.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,691,599.00	11.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(19,432,764.38)</b>	<b>(24,741,322.32)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(19,432,764.38)</b>	<b>(24,741,322.32)</b>

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>699,888,024.00</b>	<b>857,580,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>875,000.00</b>	-
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	875,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	875,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>699,013,024.00</b>	<b>857,580,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	683,996,000.00	643,164,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	683,996,000.00	643,164,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	14,116,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	14,116,500.00

«Audit\_name» «Audit\_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	200,299,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	200,299,800.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	15,000,000.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	15,000,000.00	-
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	17,024.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	17,024.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>674,065,371.00</b>	<b>811,275,539.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>674,065,371.00</b>	<b>811,275,539.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>662,321,484.00</b>	<b>796,733,527.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	346,900,822.00	484,038,390.74
210101	Үндсэн цалин	271,450,822.00	336,712,100.00
210102	Нэмэгдэл	45,000,000.00	81,678,000.00
210104	Урамшуулал	30,000,000.00	65,648,290.74
210105	Гэрээт ажлын хөлс	450,000.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,472,094.00	60,504,900.00
210201	Тэтгэврийн даатгал	27,925,300.00	40,903,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,490,700.00	4,900,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,792,500.00	3,920,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	875,054.00	980,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,388,540.00	9,800,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	187,500,392.00	198,771,800.00
210301	Гэрэл, цахилгаан	13,253,192.00	15,680,000.00
210302	Түлш, халаалт	164,247,200.00	166,913,300.00
210303	Цэвэр, бохир ус	10,000,000.00	16,178,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	33,475,710.00	13,223,532.00
210401	Бичиг хэрэг	1,957,300.00	876,400.00
210402	Тээвэр, шатахуун	635,000.00	1,485,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,754,274.00	1,696,582.00

«Audit\_name» «Audit\_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэл	362,916.00	60,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	206,000.00	430,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,560,220.00	8,674,650.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>9,759,776.00</b>	<b>20,434,200.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	100,000.00
210502	Хоол, хүнс	4,657,528.00	19,214,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,002,248.00	1,119,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,670,000.00</b>	<b>1,528,000.00</b>
210604	Урсгал засвар	32,670,000.00	1,528,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>330,000.00</b>	<b>330,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	330,000.00	330,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>639,760.00</b>	<b>690,930.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	639,760.00	612,430.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	78,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,572,930.00</b>	<b>17,211,775.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,822,930.00	5,701,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,750,000.00	11,510,175.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,743,887.00</b>	<b>14,542,011.26</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,052,288.00</b>	<b>14,542,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	17,024.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,661,764.00	13,307,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	373,500.00	1,235,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,691,599.00</b>	<b>11.26</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,691,599.00	11.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>25,822,653.00</u></b>	<b><u>46,304,961.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>26,185,569.00</b>	<b>46,304,961.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,185,569.00</b>	<b>46,304,961.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>26,185,569.00</b>	<b>46,304,961.00</b>

«Audit\_name» «Audit\_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

222001	Тоног төхөөрөмж	26,185,569.00	46,304,961.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(26,185,569.00)</b>	<b>(46,304,961.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(362,916.00)	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	362,916.00	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,700,000.00		4,272,955,612.51		4,395,655,612.51
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,700,000.00	-	4,272,955,612.51	-	4,395,655,612.51
C07	Тайлант үеийн үр дүн			-24,741,322.32		(24,741,322.32)
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,700,000.00	-	4,272,955,612.51	-	4,395,655,612.51
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	122,700,000.00	-	4,272,955,612.51	-	4,395,655,612.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,700,000.00	-	4,272,955,612.51	-	4,395,655,612.51
D08	Тайлант үеийн үр дүн			-24,741,322.32		(24,741,322.32)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,700,000.00	-	4,248,214,290.19	-	4,370,914,290.19

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгий	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
--------------	----------	-----------	-------------

«Audit\_name» «Audit\_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Н ангила л		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.00	0.00	762090000.00	811275527.74
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	0.00	762090000.00	811275527.74
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	0.00	747598000.00	796733527.74
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.00	0.00	480038400.00	484038390.74
210101	Үндсэн цалин			326712100.00	336712100.00
210102	Нэмэгдэл			81678000.00	81678000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт			0.00	65648290.74
210104	Урамшуулал			71648300.00	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	0.00	0.00	60004900.00	60504900.00
210201	Тэтгэврийн даатгал			40803300.00	40903300.00
210202	Тэтгэмжийн даатгал			4800400.00	4900400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал			3840300.00	3920300.00
210204	Ажилгүйдлийн даатгал			960100.00	980100.00
210205	Эрүүл мэндийн даатгал			9600800.00	9800800.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	0.00	0.00	180063100.00	198771800.00
210301	Гэрэл, цахилгаан			9600000.00	15680000.00
210302	Түлш, халаалт			160987200.00	166913300.00
210303	Цэвэр, бохир ус			9475900.00	16178500.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	0.00	3905300.00	13223532.00
210401	Бичиг хэрэг			499900.00	876400.00
210402	Тээвэр, шатахуун			635100.00	1485000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр			974,300.00	1,696,582.00
210404	Ном, хэвлэл			514,300.00	60,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал			214,500.00	430,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс			1,067,200.00	8,674,650.00
2105	<b>Нормативт зардал</b>	-	-	18,234,200.00	20,434,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл			100,000.00	100,000.00
210502	Хоол, хүнс			17,015,300.00	19,214,700.00

«Audit\_name» «Audit\_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл			1,118,900.00	1,119,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	-	1,528,000.00	1,528,000.00
210604	Урсгал засвар			1,528,000.00	1,528,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-	330,000.00	330,000.00
210702	Дотоод албан томилолт			330,000.00	330,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	-	718,500.00	690,930.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			640,000.00	612,430.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			78,500.00	78,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	-	2,775,600.00	17,211,775.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал				5,701,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			2,775,600.00	11,510,175.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-	14,492,000.00	14,542,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-	14,492,000.00	14,542,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал			13,257,000.00	13,307,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			1,235,000.00	1,235,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	200,299,800.00	200,299,811.26
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	11.26
131001	Улсын төсвөөс санхүүжих				11.26
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	200,299,800.00	200,299,800.00
132001	Орон нутгийн төсвөөс			200,299,800.00	200,299,800.00